



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2013.07.30 № 02/6301
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас томилогдсон ажлын хэсэг 2014 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 07 дугаар сарын 04-ний өдөр хүртэл Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, 13 суманд ажилласан.

Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилттэй танилцах явцад дараахь нийтлэг зөрчил, дутагдал илэрсэн:

1. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулалгүй томилсон, Үнэлгээний хорооны гишүүд Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргалгүйгээр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулдаг, албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах;

2. Төрийн жинхэнэ албан хаагчид аймаг, сумдын иргэдийн Хурлын Төлөөлөгчийн сонгуульт ажлыг давхар гүйцэтгэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан “Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт”-ыг болон Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 - д “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдох, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэхийг хориглоно.” гэж заасныг зөрчих;

3. Зарим сумын Засаг дарга нараас Иргэд байгууллагад хандан ойн арга хэмжээ тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан хүсэлт гарган хандив авах байдлаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх “... Санхүүгийн туслалцаа авах, хүсэхийг хориглоно.” заалтыг зөрчих;

4. Сумдын Засаг дарга нар нутгийн Зөвлөлийг хүлээн авч сар шинийн золголт хийх, Оюутан залуучуудын чуулга уулзалтын арга хэмжээ, баяр наадмын үндэсний

бөхийн барилдаанд оролцох бөхчүүдийн бэлтгэлд, бүсийн хурдан морины уралдаанд нэгдсэн зохион байгуулалттай оролцох, орон нутагт томилолтоор ажиллаж буй Засгийн газрын болон яам агентлаг, Нийслэлийн дүүргийн Засаг дарга нарын бүрэлдэхүүний хоол, байрны зардал гэх мэт олон арга хэмжээний хөрөнгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан нь Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-д заасныг баримтлаагүй байх бөгөөд Засгийн газрын 2002 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах, зарим арга хэмжээний тухай” тогтоолоор орон нутгийн чанартай наадам, урлаг спортын төрөл бүрийн тэмцээн зохион байгуулах, салбарын ой тэмдэглэх зэргийг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглохоор заасныг илтэд зөрчиж ... үр ашиггүй зарцуулсан шийдвэрүүд гаргах;

5. Засгийн газрын 271 дүгээр тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс Баяр наадмын зардалд тогтоосон жишиг хэмжээнээс хэт их хэтрүүлэн төлөвлөж, зарцуулах,

6. Орон нутгийг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа бусдад давуу байдал олгох, гэрээний шаардлагыг хангуулан чанартай гүйцэтгүүлэх талаар явц байдлын хяналт хангалтгүй байснаас зарим нэгэн ажил чанаргүй хийгдэх;

7. Мөн Халзан суманд Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт орж ирээгүй гэх шалтгаанаар Хатуу хучилттай авто зам барих ажилд 25.716.000 /хорин таван сая долоон зуун арван зургаан мянга/ төгрөгийг авч ашиглаад буцаан төвлөрүүлсэн, Авто замын урьдчилгаанд 10.000.0000 /арван сая/ төгрөг зарцуулсан байсан гэх мэт Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын хавсралт “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.9 дэх хэсэгт заасныг зөрчих;

8. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэд төслийн дагуу үйл ажиллагаа явуулаагүй, зориулалтын бусаар ашигласан, огт үйл ажиллагаа явуулаагүй, бусдын нэрээр зээл авч эргэн төлөлтийг хийдэггүй, зээл авсан төслийн материал олдохгүй байх, ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжгүйгээр хөрөнгө гаргах зэрэг зөрчлүүд сум бүрт нийтлэг байгаа зэрэг болно.

Авлигатай тэмцэх газрын даргын 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 01/4350 дугаар “Зөвлөмж”-ийн дагуу авсан арга хэмжээ, ЗДТГ-ын авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөө, Тамгын газрын ил тод байдал, иргэдээс гомдол мэдээлэл хүлээн авч шийдвэрлэж байгаатай танилцахад Зөвлөмжийн биелэлт болон төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байлаа.

Авлигын эсрэг үйл ажиллагааг АТГ-аас хүргүүлсэн аргачлалын дагуу төлөвлөн хэрэгжүүлэх, хуульд заасан зохих бүртгэлүүдийг бий болгох, дотоод хяналтын нэгжид албан хаагчдын ёс зүйн зөрчлийн мэдээлэл хүлээн авах тогтмол утас ажиллуулах, Зөвлөмжид тусгасан 22 ажил, Авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөнд тусгасан 68

ажлыг хэрхэн хэрэгжүүлэх талаар Эрх бүхий албан тушаалтанд мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Иймд Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг чанд мөрдөж, дээр дурьдсан зөрчил дутагдлыг дахин гаргахгүйгээр ажиллах талаар ЗДТГ, эрхлэх асуудлын хүрээний байгууллага, сумын удирдлага, албан тушаалтнуудад чиглэсэн тодорхой ажлуудыг зохион байгуулахыг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалтын дагуу авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих бүрэн эрхийнхээ хүрээнд Зөвлөмж болгож байна.

Зөвлөмжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2014 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Ажлын хэсгийн *АБ* хуудас тайланг хавсаргав.

ДЭД ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Б.ХУРЦ